



## МАЛЧДАД ЗОРИУЛСАН ТӨСӨЛ, ХОТӨЛБӨР

**МАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСӨЛ:** Малын эрүүл мэндийг сайжруулах, малчдын хамтын санаачлагыг нэмэгдүүлэх зорилготойгоор Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Сайншанд сумын Зүүнбаян багт 2014 – 2017 оны хооронд Монголын нэгдсэн хувийн мал эмнэлгүүдийн дундын хоршоогоор дамжуулан орон нутгийн хувийн мал эмнэлгүүдтэй хамтран хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд малын гурван эмчээс бүрдсэн баг Сайншанд суманд байрлаж, тухайн бүсийн нийт малчин өрхийн 78 хувь буюу 239 айлын 1600 толгой малд эмнэлгийн үзлэг, оношлогооны үйлчилгээг нийт 814 удаа үзүүлсэн. 2015, 2016 онд 1429 айлын 8036 бод, 545828 бог малд угаалга, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ үзүүлжээ.

### **БЭЛЧЭЭРИЙН УСАН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ:**

Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор малчдын худаг засварын төслийг 2015 оноос малчдын оролцоотойгоор жил бүр хэрэгжүүлж байгаа ба төслийн хүрээнд нийт 50 гаруй худгийг сэргээн засварлаад байна.

Засварлах шаардлагатай худгийн мэдээлэл болон хүсэлтээ малчид багийн дарга нарт гарган, Хамтын ажиллагааны зөвлөлд танилцуулснаар тухайн жилийн засварлах худгийг сонгодог.

**2015, 2016 онд  
1429 айлын 8036  
бод, 545828 бог  
малд угаалга,  
халдваргүйжүүлэлтийн  
үйлчилгээ үзүүлжээ.**



Төслийн явцын тухай мэдээллийг бидний Фэйсбүүк хуудаснаас авна уу.  
<https://www.facebook.com/badrakhenergy>